

Биологийн хөрөнгийн бүртгэл, тайлагналын асуудалд

In Matters of Accounting and Reporting of Biological Assets

Д. Эрдэнэсоёл¹

Хураангуй

Олон улсын хэмжээнд ХАА-н салбарын аж ахуйн нэгжүүдийн нягтлан бодох бүртгэлд тулгамдсан асуудал их байна. Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт дахь НББОУС-41 “Хөдөө аж ахуй”-н хэрэглээ харилцан адилгүй байна. Иймд уншиж судалсан материалаасаа түүвэрлэн НББОУС-41 болон бусад эрх зүйн баримтуудтай уялдуулан үндэсний стандарт болон зааварчилгаа, гарын авлага боловсруулж хэрэгжүүлж буй хөдөө аж ахуйн стандартын хэрэглээний хувьд өөрийн оронтой ойролцоо 10 улсыг төлөөлүүлэн авч судлав. Улмаар Монгол улсын Сангийн сайдын 2016 оны 411 тоот тушаалаар батлагдсан “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу хагас суурин маллагаатай үхрийн фермерийн биологийн хөрөнгийг бодит үнэ цэнийн загвараар үнэлж бүртгэн, санхүүгийн тайланд толилуулах асуудлыг авч үзлээ.

Түлхүүр үгс: хөдөө аж ахуй, мал аж ахуй, бодит үнэ цэнэ, биологийн хөрөнгө, үнэлгээ

Abstract

Internationally, there are many challenges in the accounting of agricultural enterprises. The use of IAS-41 “Agriculture” in International Financial Reporting Standards varies. Therefore, we selected 10 countries that are close to their own country in terms of the application of national standards and guidelines and manuals in accordance with IAS-41 and other legal documents. Subsequently, the “Accounting Standards for Biological Assets and Agricultural Products Received from them” approved by the Order No. 411 of the Minister of Finance of Mongolia in 2016 was selected. Accordingly, the biological assets of semi-settled cattle farmers are valued and recorded in the financial statements.

Keywords: agriculture, international, national, law, standard, fair value, biological assets, valuation, livestock

¹ МУИС-ийн Завхан сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: erdenesoyol@num.edu.mn

Үндэслэл

Аливаа улс орны хувьд Хөдөө аж ахуй (ХАА) бол эдийн засгийн үндсэн салбаруудын нэг бөгөөд хүн амыг хүнс, тэжээлээр, боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах чухал үүрэгтэй. Монгол Улс бэлчээрийн мал аж ахуй (МАА) зонхилсон орон зах зээлийн эдийн засагт шилжсэнээр ХАА-н хувийн өмчид суурилсан аж ахуйн нэгжүүд үүсч жил ирэх тутам эрчимжсэн фермерийн тоо өссөөр байна. Хэдий тийм ч ХАА-н байгууллагуудын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн ангилал, хэмжилт, хүлээн зөвшөөрөлт, үнэлгээний арга хандлага, толилуулга, тодруулгын байдал нь СТОУС-д бүрэн нийцэхгүй байна (Алтанцэцэг & Одончимэг 2016). Биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоох тодорхой аргачлалыг бий болгох шаардлагатай. Манай улсад одоогоор ХАА-н биржийн үнийг жишиг болгон авч болох ч тус бирж дээр ноос, ноолуур, арьс шир зэрэг ХАА-н бүтээгдэхүүнүүд ихэвчлэн арилжаалагдаж байна. Харин сүүний үнээ, гахай, тахиа зэрэг биологийн хөрөнгүүд төдийлөн идэвхтэй арилжаалагдахгүй байгаа нь бодит үнэ цэнийг тогтооход бэрхшээл үүсгэж байна (Баярхүү & Оюунчимэг 2016).

Эрдэнэсоёл (2019) ХАА-н салбар өндөр хөгжсөн зарим улс орнуудын (Австрали, Шинэ Зеланд, Канад, Өмнөд Африк, Их Британи, Бразил, АНУ) туршлагаас биологийн хөрөнгийн үнэлгээний арга хандлагыг судалж НББОУС-41-ийн дагуу зах зээлийн үнэд суурилсан бодит үнэ цэнийн аргыг хэрэглэж буй дүр зураг харагдсан.

Манай улсад 2019 оны эцсийн байдлаар 2497 өрх, аж ахуй нэгжид 100.9 мянган сүүний үхэр; 475 өрх, аж ахуйн нэгжид 33.7 мянган махны үхэр; 1591 өрх, аж ахуйн нэгжид 45.9 мянган мах, ноосны хонь; 731 өрх, аж ахуйн нэгжид 21.3 мянган гахай; 1528 өрх, аж ахуйн нэгжид 956.0 мянган өндөглөгч тахиа; 900 өрх, аж ахуйн нэгжид 12250 бүл зөгий; мөн түүнчлэн зарим иргэд цаа буга, илжиг, загас, цөөн тооны цацагт хяруул, галуу, нугас, туулай зэргийг үржүүлж байна (ХХААХҮЯ, 2019, mofa.gov.mn).

ХХААХҮЯ-аас бэлтгэсэн эрчимжсэн мал аж ахуйн статистик мэдээллээс 2005, 2010, 2015, 2019 онуудаар түүвэрлэн авч нэгтгэн харьцуулав (Хүснэгт 1).


МАА-н фермерийн тооны өөрчлөлт 2005 оныг 2010 онтой харьцуулахад 4.6 дахин;

Хүснэгт 1. Эрчимжсэн мал аж ахуйн фермер (тоо)

Аж ахуйн төрөл	2005	2010	2015	2019
Сүүний үхрийн фермерийн аж ахуйн тоо	186	649	1,172	2,497
Махны үхрийн фермерийн аж ахуйн тоо	11	101	248	475
Мах, ноосны хонины ферм	12	128	397	1,591
Сүүний чиглэлийн ямааны ферм	-	-	6	-
Гахайн ферм	21	190	331	Ферм - 144 Өрх - 587
Тахиан ферм	38	148	244	Ферм - 57 Өрх - 1,471
Зөгийн ферм	16	68	161	Ферм - 56 Өрх - 844
Туулайн ферм	-	10	50	
Бүгд	284	1,294	2,609	7,722

Эх сурвалж: <http://mofa.gov.mn>

Зураг 1. Эрчимжсэн үхрийн фермерийн байршил, хувиар, 2019 он



Эх сурвалж: <http://mofa.gov.mn>

2010 оныг 2015 онтой харьцуулахад 2 дахин; харин 2015-2019 он хүртэл 3 дахин тус тус өссөн. Бүтцийн хувьд үхрийн аж ахуй дийлэнх хэсгийг эзэлж байна. Тухайлбал: 2005 онд 69%, 2010 онд 58%, 2015 онд 35%, 2019 онд 38.5%-ийг тус тус эзэлж байна. Дунджаар үхрийн аж ахуйн 87% нь сүүний, 13% нь махны чиглэлийн аж ахуй эзэлж байна.

2019 онд эрчимжсэн үхрийн фермер аж ахуй нийт 2,972 байна. Эдгээр нь Улаанбаатар хот, 21 аймгийн нутгийг хамарч Улаанбаатар хот, Төв, Сэлэнгэ, Дорнод, Өвөрхангай, Архангай, Хэнтий, Дархан-Уул аймгийн бүс нутгаар (84.9%) илүү хөгжиж байгаа нь Зураг 1-ээс харагдаж байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болон Биологийн хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийн асуудлаар нийтэлсэн 50 гаруй гадаад өгүүлэл болон Дэлгэрэх- Алдар ХХК-ийн 2016-2018 онуудын жилийн эцсийн мал тооллогын мэдээ, тухайн үеийн малын зах зээлийн үнэ, санхүүгийн тайлан, бусад мэдээллийг, судалгааны тооцооллод ашиглав.

Сэдвийн судлагдсан байдал

Van Biljon (2016) улс орнуудыг харьцуулах явцдаа биологийн хөрөнгийн үнэлгээ,

бүртгэлийн арга аргачлал нь улс орон бүрт ялгаатай, харьцуулагдах боломжгүй байдлыг илрүүлсэн. Ийм учраас биологийн хөрөнгийг хэрхэн бодитоор үнэлэх боломжийг эрэлхийлж, улмаар биологийн хөрөнгийн үнэлгээний аргуудын талаархи мэдээллийг цуглуулах, задлан шинжлэх, санхүүгийн тайлан хэрэглэгчдэд танилцуулах мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах, удирдлагын шийдвэр гаргахад туслах удирдамжийг боловсруулсан байна.

Maina (2010) Кени улсын хөдөө аж ахуйн салбарын бүтэц, энэ салбар дахь технологийн хувьсал, бодит үнэ цэнийн үзэл баримтлалын талаар судалж, 27 жижиг, дунд аж ахуйн нэгжүүдээс (фермерүүдээс) нягтлан бодох бүртгэл хөтлөлт, биологийн хөрөнгийн үнэлгээ болон зах зээлийн талаар асуулгын аргаар судалгаа аван боловсруулж бодит үнэ цэнийн аргын хэрэглээнд тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлон биологийн хөрөнгийн үнэлгээнд зах зээлийн болон орлогын хандлагыг хэрэглэх саналыг дэвшүүлэн тавьсан.

Алтанцэцэг (2018) зах зээлийн нөхцөлд мал аж ахуйн үйлдвэрлэлийн зардлын бүртгэлийн системийг зохион байгуулах,

бүтээгдэхүүний өртгийн тооцооллыг шинэчлэн боловсронгуй болгох арга замыг тодорхойлохыг зорьж, 20 гаруй сүүний чиглэлийн үхрийн фермерүүдийг судлан зардал хуваарилалтын шинэ суурь үзүүлэлтээр “бүтээгдэхүүний найрлага дахь шимт чанарын бодис болох уураг байна” гэсэн саналыг дэвшүүлжээ.

Алтанцэцэг нар (2016) хөдөө аж ахуйн 40 компанийг судалгаанд хамруулж харьцуулан шинжилж, мал аж ахуй эрхлэгч аж ахуйн хувьд сүргийн эргэлтийн, үржлийн мал амьтдын үнэ цэнэ, ХАА-н бүтээгдэхүүний өртөг, биологийн хөрөнгийн анхдагч болон тайлангийн үеийн тооцоо бүртгэлийг НББОУС-41 буюу ХАА-д нийцсэн, манай нөхцөлд тохирсон арга зүйгээр хөтлөх тайлагнах нь зайлшгүй шаардлагатай болохыг тодорхойлж дүгнэсэн. Цаашид малчны бүлэг, тариалан эрхэлдэг өрхийн аж ахуй зэрэг албан ёсны аж ахуйн нэгжийн статусгүй иргэдэд зарим улс орнуудын (Латви, Эстони) жишгээр бизнесийн орлого, зардал, ашигаа тооцох тусгайлан журам аргачлал боловсруулахыг санал болгожээ.

Хөдөө аж ахуйн нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, эрх зүйн асуудалд

Хөдөө аж ахуйн үйл ажиллагааны анхны бие даасаны стандартыг (НББОУС-41 - Хөдөө аж ахуй) 2000 онд гаргасан бөгөөд 2003 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэх жилийн санхүүгийн тайлангаас хэрэгжиж эхэлсэн (iasplus.com). Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд ашигласан бусад төрлийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг Хүснэгт 2-т үзүүлэв.

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2015 онд шинэчлэгдэн батлагдсан. Тус хуулийн 4-р зүйлд Олон нийтэд нээлттэй том аж ахуйн нэгж байгууллагууд СТОУС; жижиг, дунд аж ахуйн нэгжүүд ЖДААН-ийн СТОУС; төсөвт байгууллагууд УСНББОУС-ыг тус тус хэрэглэхээр заасан. Иймд Хөдөө аж ахуйд НББОУС-41, ЖДААН СТОУС 34-р хэсэг, УСНББОУС 27-г ашиглахыг хуульчилсан. Мөн Сангийн сайдын 2016 оны 411 тоот тушаалаар “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн

Хүснэгт 2. Биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай хамааралтай бусад хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн стандарт

Биологийн хөрөнгө, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн	НББОУС-41 - Хөдөө аж ахуй, СТОУС-13 - Бодит үнэ цэнийн хэмжилт
Эх ургамал (bearer plants)	НББОУС-16 - Үндсэн хөрөнгө
Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой газар	НББОУС-16 - Үндсэн хөрөнгө
	НББОУС-40 - Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой биет бус хөрөнгө	НББОУС-38 - Биет бус хөрөнгө
Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа явуулах зорилгоор түрээслэсэн газарт хөрөнгө ашиглах эрх	СТОУС-16 - Түрээс
Эх ургамалтай холбоотой засгийн газрын буцалтгүй тусламж	НББОУС-20 - Засгийн газрын буцалтгүй тусламж ба тусалцааны тодруулга
Хүлээн авалтын үеийн дараах боловсруулсан бүтээгдэхүүн	НББОУС-2 - Бараа материал

Эх сурвалж: СТОУС

стандарт” гэсэн үндэсний стандартыг баталсан. Уг стандартын хамрах хүрээний хувьд фермерийн мал аж ахуй болон газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн эх ургамлаас бусад биологийн хөрөнгө; Хүлээн авалтын үеийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн ба Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой засгийн газрын буцалтгүй тусламж зэрэг зүйлд ашиглана гэж заасан.

НББОУС-41 болон бусад эрх зүйн баримтуудтай уялдуулан үндэсний стандарт болон зааварчлагаа, гарын авлага боловсруулж, хэрэгжүүлж буй хөдөө аж ахуйн стандартын хэрэглээний хувьд Монгол оронтой ойролцоо гэж үзэн Малайз, Филиппин, Турк, Австрали, Литва, Бразил, Хятад, Орос, Казакстан улсуудыг сонгон хамруулав. Судалгааг Хавсралт №1-д харуулав.

Биологийн хөрөнгийн бүртгэл тайлагналын асуудалд

Биологийн хөрөнгө гэдэг нэр томъёо нь компанийн хөдөө аж ахуйн үйл ажиллагааны нэг хэсэг болох амьд амьтан, ургамлыг хэлдэг. НББОУС-41-д

биологийн хөрөнгийг бодит үнэ цэнийн аргаар хэмжихийг шаарддаг. Биологийн хөрөнгийн ангилал бүр нягтлан бодох бүртгэлийн тусгай зохицуулалт шаарддаг. Мал амьтан, ХАА-н бүтээгдэхүүн ба ургаж буй үржлийн ургамал дахь бүтээгдэхүүнийг НББОУС-41-ийн хамрах хүрээний дагуу бодит үнэ цэнийн аргаар хэмжиж бүртгэнэ. Харин НББОУС-16-д хамаарах эх ургамлыг ургаж гүйцэх хүртэл ихэвчлэн өртгөөр нь хэмжинэ. Ургаж гүйцсэнээс хойших өртгүүдийг хэрэв тэдгээр нь хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэхгүй байвал тайлант үеийн зардал болгоно (Зураг 2).

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилтийн өдрөөр зах зээлд оролцогчдын хоорондох ердийн ажил гүйлгээгээр хөрөнгийг борлуулсанаар хүлээн авах, эсвэл өр төлбөрийг шилжүүлсэнээр төлөх үнэ гэж СТОУС-13-д тодорхойлсон.

Бодит үнэ цэнэ бол бэлэн байгаа, мэдээлэл тооцоотой, хүсэл сонирхол бүхий талуудын хооронд хөрөнгө болон өр төлбөрийг солилцохоор тооцоолсон үнэ бөгөөд эдгээр талуудын харгалзах ашиг сонирхлыг агуулсан байна. Бодит үнэ цэнэ нь зах зээлийн үнээс арай өргөн утгатай. Ихэнх тохиолдолд хоёр талын хооронд бодит байх үнэ нь зах зээл дээр хүрч болох үнэтэй тэнцдэг тул зах зээлийн үнэ цэнийн тооцоололд харгалзаж үздэггүй, ашиг сонирхлоо нэгтгэсэнээс бий болох тусгай үнэ цэнийн тооцоололд оруулан авч үзэх нь бий (ҮОУС, 2011, 27-р тал).

Iudicibus & Martins нар 2006 оны бүтээлдээ бодит үнэ цэнийн тухай ойлголт нэлээд эртний бөгөөд 1939 онд Kenneth MacNeal уг сэдвийг бодит, үнэн гэсэн нэр томъёог ашиглан хөндөж, эдийн засгийн утгыг үнэлгээнд тусгасан. Улмаар Barth (1994),

Зураг 2. Биологийн хөрөнгийн бүртгэлийн загвар



Эх сурвалж: Rejeb нар (2017)

Lisboa & Scherer (2000), Argiles & Slob (2001), Elad (2004), Herbohn & Herbohn (2006), Herbohn (2006) ба Rech нар (2006) мөн биологийн хөрөнгөд анхаарлаа хандуулсан байна (Brito нар, 2014).

Судалгаа

“Дэлгэрэх-Алдар” ХХК нь анх 2002 онд 9 гишүүний бүрэлдэхүүнтэй хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах зорилгоор Улаанбаатар хотоос сайн үүлдрийн 13 үнээ авчирч Завхан аймгийн Алдархаан суманд хагас байран маллагаатай байгуулагдаж байсан Завхан аймгийн ууган фермерүүдийн нэг юм. Завхан аймгийн төв Улиастайгаас баруун тийш 30 км газар байрладаг. 2018 оны байдлаар саалийн 20 үнээ, 19 тугал, 5 бяруу, 5 охин шүдлэн зэрэг толгой малтай байна (Хүснэгт 3). Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болох сүүг Жавхлант цогцолбор сургуульд гэрээний нийлүүлэлт хийж байна. Мал борлуулалтын үйл ажиллагаа нь туслах аж ахуйн зориулалтаар хийгддэг.

Баталгаажсан санхүүгийн тайланд биологийн хөрөнгийн үзүүлэлтэнд толилуулсан дүн байхгүй байна.

Дэлгэрэх-Алдар үхрийн фермерийн биологийн хөрөнгийг ангилах оролдлого хийсэн. Фермер нь эр туглыг бяруу болохоор нь зарах, эсвэл дотоод хэрэгцээний зорилгоор ашигладаг учраас эр тугал, эр бярууг таваарын биологийн

хөрөнгө гэж ангилав. Харин үлдсэн эм тугал, эм бяруу, эм шүдлэн, үнээ, бух зэрэг үхрүүд эх буюу үржлийн биологийн хөрөнгөд хамрагдаж байна. Эдгээр үржлийн биологийн хөрөнгө нь нэгээс дээш тайлангийн үеүдэд ашиг шимээ өгч, амьдралынхаа хугацаанд бүтээгдэхүүн бий болгодог нөхөн үйлдвэрлэгч хөрөнгө юм.

Бодит үнэ цэнийн тооцоолол:

Зах зээлийн үнэд суурилсан нэгжийн бодит үнэ цэнийн тооцооллыг хийхдээ нэг малын зах зээлийн үнээс борлуулах зардлыг хассан дүнгээр нэгжид ногдох борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ (БЗХБҮЦ)-ийг тодорхойлов. Борлуулах зардалд тээврийн зардал, ажлын хөлсний зардлуудыг хамруулсан. Алдархаан сумаас Завхан аймгийн төв Улиастай сумд ирээд буцахад 20 литр шатахуун зарцуулна. Нэг литр шатахууны үнэ 2016 онд 1580₮, 2017 онд 1530₮, 2018 онд 1630₮, нэг хүний ажлын хөлсийг 15,000₮, ажил гүйлгээний тоо 20. Шатахууны үнэ дээр ажлын хөлсөө нэмээд ажил гүйлгээний тоонд харьцуулан нэг мал (хувьсах зардал)-д ноогдох байдлаар тооцсон болно. Тухайлбал: 2016 онд 1 настай малд ноогдох тээврийн зардал $2,330 \left[\frac{(1,580 \cdot 20) + 15,000}{20} \right]$, бодит үнэ цэнэ 297,670 (300,000-2,330) төгрөг болов. Нэг толгой үхрийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тооцсоноор

Хүснэгт 3. Үхрийн фермерийн биологийн хөрөнгийг ангилсан байдал

Ангилал		Үхрийн нас, хүйс	2016	2017	2018
Таваарын биологийн хөрөнгө	Эргэлтийн хөрөнгө	Эр төл / тугал	11	4	10
		1 настай эр үхэр / бяруу	3	5	1
Эх буюу үржлийн биологийн хөрөнгө	Эргэлтийн бус хөрөнгө	Хээлтүүлэгч / бух	1	1	1
		Эм төл / тугал	5	6	9
		1 настай эм үхэр / бяруу	3	5	4
		2 настай эм үхэр / шүдлэн	2	0	5
		3 настай эм үхэр / үнээ	17	21	20
Бүгд			42	42	50

Хүснэгт 4. Нэг толгой үхрийн бодит үнэ цэнийн тооцоолол (төгрөг)

Он	Нас	Зах зээлийн үнэ	Борлуулалтын зардал	Бодит үнэ цэнэ
2016	Төл мал	40,000.00	-	40,000.00
	1 настай үхэр	300,000.00	2,330.00	297,670.00
	2 настай үхэр	390,000.00	3,883.33	386,116.67
	3 настай үхэр	650,000.00	1,792.31	648,207.69
2017	Төл мал	50,000.00		50,000.00
	1 настай үхэр	320,000.00	2,072.73	317,927.27
	2 настай үхэр	400,000.00	2,533.33	397,466.67
	3 настай үхэр	680,000.00	1,381.82	678,618.18
2018	Төл мал	55,000.00		55,000.00
	1 настай үхэр	330,000.00	2,630.00	327,370.00
	2 настай үхэр	420,000.00	5,260.00	414,740.00
	3 настай үхэр	700,000.00	1,696.77	698,303.23

Хүснэгт 5. Фермерийн таваарын болон үржлийн үхрийн бодит үнэ цэнийн тооцоо, мянган төгрөгөөр

Үхрийн ангилал	Үхрийн нас	Нэгжийн БЗХБҮЦ			Малын тоо толгой			Нийт БЗХБҮЦ		
		2016	2017	2018	2016	2017	2018	2016	2017	2018
Таваарын биологийн хөрөнгө	Төл эр	40.0	50.0	55.0	11	4	10	440.0	200.0	550.0
	1 наст эр	297.7	317.9	327.4	3	5	1	893.0	1,589.6	327.4
Дүн								1,333.0	1,789.6	877.4
Үржлийн биологийн хөрөнгө	Төл эм	40.0	50.0	55.0	5	6	9	200.0	300.0	495.0
	1 наст эм	297.7	317.9	327.4	3	5	4	893.0	1,589.6	1,309.5
	2 наст эм	386.1	397.5	414.7	2	0	5	772.2	-	2,073.7
	3 наст эм	648.2	678.6	698.3	17	21	20	11,019.5	14,251.0	13,966.1
Дүн								12,884.8	16,140.6	17,844.2
Дүн								14,217.8	17,930.3	18,721.6

цаашид таваарын болон үржлийн үхрийн бодит үнэ цэнэ болон, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тодорхойлох, санхүүгийн тайланд толилуулах биологийн хөрөнгийн дүнг тодорхойлно (Хүснэгт 4).

Бодит үнэ цэнийн тооцооллоор эргэлтийн хөрөнгөнд таваарын биологийн хөрөнгийг 2016 онд 1,333.0 мянган төгрөг; 2017 онд 1,789.6 мянган төгрөг; 2018 онд 877.3 мянган төгрөгийн бодит үнэ цэнээр толилуулна. Харин үржлийн биологийн хөрөнгийг 2016 онд 12,884.7 мянган төгрөг; 2017 онд 16,140.6 мянган төгрөг; 2018 онд 17,844.2 мянган төгрөгийн бодит

үнэ цэнээр тус тус толилуулахаар тооцов (Хүснэгт 5).

Малын нас дэвших гэдэг нь бага насны мал доод наснаас дараагийн шатны дээд насны бүлэгт шилжих үйл явц юм. Сүрэгт байгаа нэг хүйсийн малыг шинэ он гарах тутамд дараагийн дээд насны бүлэг рүү бүртгэлээр шилжүүлдэг. Жишээлбэл: тайлангийн жилд гарсан тугал оны эцэст бэлэн байгаа тоогоороо дараа ондоо бяруу болж хувирна гэх мэтээр бусад насны мал мөн нас нэмнэ. Уг фермерийн хувьд 2016-2018 оны дунджаар жилд 38 үхэр нас дэвшүүлж 19 үнээнээс 15 төл

Хүснэгт 6. Биологийн хөрөнгөнөөс төл хүлээн авах үеийн бодит үнэ цэнэ

Он	Хүлээн авсан төл, тоо толгой	Нэгжийн бодит үнэ цэнэ, төгрөг	Биологийн хөрөнгийн анхдагч хүлээн зөвшөөрөлтийн олз, төгрөг
2016	16	40,000	640,000
2017	10	50,000	500,000
2018	19	55,000	1,045,000

Хүснэгт 7. Журналын бичилт

Харьцсан данс		Он		
Дт	Кт	2016	2017	2018
<i>ЖБ1: Шинэ төл хүлээн авах үеийн бүртгэл</i>				
Биологийн хөрөнгө (төл мал)	Биологийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсөн үеийн БҮЦ-ийн олз	640,000	500,000	1,045,000
<i>ЖБ2: Үнийн өөрчлөлтөөс бий болсон олз, гарзыг бүртгэх</i>				
Биологийн хөрөнгө	Биологийн хөрөнгийн дахин хэмжилтээс үүссэн БҮЦ-ийн олз	-	790,811	341,278
<i>ЖБ3: Нас дэвшилтээс бий болсон олз гарзыг бүртгэх</i>				
Биологийн хөрөнгө	Биологийн хөрөнгийн дахин хэмжилтээс үүссэн БҮЦ-ийн олз	16,463,932	23,104,194	14,954,132
<i>ЖБ4: Мал борлуулах үеийн бүртгэл</i>				
Мөнгөн хөрөнгө	Борлуулалтын орлого (нас гүйцсэн)	13,862,416	19,112,945	30,326,348
Борлуулалтын зардал	Борлуулалтын орлого (нас гүйцсэн)	87,584	87,055	84,415
<i>ЖБ5: Борлуулсан малын өртгийг бүртгэх</i>				
Борлуулалтын өртөг	Биологийн хөрөнгө (нас гүйцсэн)	13,862,416	19,112,945	30,326,348

хүлээн авч бойжуулсан ба 1-3 насны 35 үхэр борлуулжээ.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт:

Борлуулах зардлыг хасаж тооцсон бодит үнэ цэнэ нь тоо хэмжээний болон зах зээл дээрх үнийн өөрчлөлтөөс үүдэн өөрчлөгдөж болно.

Үнийн өөрчлөлтийг тухайн насны малын оны эхний болон хүлээн авсан ба худалдан авсан малын тоог тухайн насны малын оны эцэс ба эхний бодит үнэ цэнийн зөрүүгээр үржүүлнэ.

Тоо хэмжээний өөрчлөлтийг тухайн насны малын тоог дээд ба тухайн насны малын оны эцсийн бодит үнэ цэнийн зөрүүгээр үржүүлж тодорхойлно (СТОУС-ын хэрэглээний тайлбар, 2014).

Биологийн хөрөнгийг бодит үнэ цэнээр

хэмжих бөгөөд үнийн өөрчлөлтийг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тайлант үе бүрийн үнэ цэнийн зөрүү юм (Хүснэгт 6).

Биологийн хөрөнгийн дахин хэмжилтээс үүссэн бодит үнэ цэнийн олз, гарзын тооцоог Хавсралт 2-т харуулав.

Биологийн хөрөнгийг бодит үнэ цэнийн загвараар үнэлсэн үнэлгээний дүнгээр журналын бичилт (ЖБ) хийв (Хүснэгт 7).

Дээрх тооцооллоос Дэлгэрэх-Алдар үхрийн фермерийн биологийн хөрөнгийн дүнг санхүүгийн байдлын тайланд биологийн хөрөнгийн ангиллын дагуу эргэлтийн хөрөнгийн хэсэгт таваарын биологийн хөрөнгийг нас гүйцсэн ба гүйцээгүй, эргэлтийн бус хөрөнгийн хэсэгт үржлийн биологийн хөрөнгийг мөн нас

Хүснэгт 8. Санхүүгийн байдлын тайлан (хэсэгчилсэн)

Үзүүлэлт	2016	2017	2018
Эргэлтийн хөрөнгө			
Таваарын биологийн хөрөнгө			
Мал амьтан:			
Нас бие гүйцсэн	893,010.00	1,589,636.35	327,370.00
Нас бие гүйцээгүй	440,000.00	200,000.00	550,000.00
Эргэлтийн бус хөрөнгө			
Үржлийн буюу эх биологийн хөрөнгө			
Мал амьтан:			
Нас бие гүйцсэн	12,684,774.07	15,840,618.13	17,349,244.60
Нас бие гүйцээгүй	200,000.00	300,000.00	495,000.00
Биологийн хөрөнгийн дүн	14,217,784.07	17,930,254.48	18,721,614.60

Хүснэгт 9. Дэлгэрэнгүй орлогын тайлан (хэсэгчилсэн)

Үзүүлэлт	2016	2017	2018
Борлуулалтын орлого - Таваарын биологийн хөрөнгийн	13,950,000.00	19,200,000.00	30,410,762.52
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг - Таваарын биологийн хөрөнгийн	13,862,416.00	19,112,945.00	30,326,348.00
Нийт ашиг	87,584.00	87,055.00	84,414.52
Биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийн олз, гарз:			
Биологийн хөрөнгийн анхдагч хүлээн зөвшөөрөлтийн олз, гарз	640,000.00	500,000.00	1,045,000.00
Биологийн хөрөнгийн Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарз (дахин хэмжилтийн)	3,392,327.88	4,332,526.20	16,752,479.09
Дүн	4,119,911.88	4,919,581.20	17,881,893.61
Үйл ажиллагааны зардал:			
Борлуулалтын зардал (тээврийн зардал)	(1,951,584.10)	(1,911,054.55)	(2,188,414.52)

гүйцсэн ба гүйцээгүй эсэх ангиллаар толилуулна (Хүснэгт 8).

Орлогын дэлгэрэнгүй тайланд борлуулсан малнаас орсон орлого, борлуулалтын өртөг, бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс бий болсон олз ба гарзын дүнг толилуулав (Хүснэгт 9).

Дүгнэлт

СТОУС-ын хувьд НББОУС-41 "Хөдөө аж ахуй" нь онцлогтой тусгай стандарт юм. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд ашигладаг зургаан төрлийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлтэй холбогдох долоон төрлийн стандарт байна.

Улс орнуудын нийгмийн хөгжил, ХАА-н

компаниудын үйл ажиллагааны онцлог, бүтэц зохион байгуулалт, цар хэмжээнээс хамааруулан НББОУС-41-ийн хэрэглээ харилцан адилгүй бэрхшээлтэй байдлаас хамааруулан уг стандарттай уялдуулан улс орнууд жижиг, дунд бизнест зориулсан дотоод стандарт, зааварчлагаа, гарын авлага гаргадаг хандлагатай байна. Литва, Австрали, Бразил, Малайз, Турк улсуудын хувьд НББОУС-41-ийн үнэлгээтэй харьцуулагдах боломжтой. Харин Казахстан, Орос, Монгол, Филиппин улсад өртгийн аргын хэрэглээ давамгайлж байгаа учир бусад орны фермертэй харьцуулах боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрэв.

Манай улсын ХХААХҮЯ-ны статистик мэдээнээс харахад үхрийн фермерийн тоо өсөлттэй, улсын нийслэл, 21 аймгийг хамарч байгаа юм. Үүнтэй уялдуулан сангийн сайдын 2016 оны 411 тоот тушаал болон Хөдөө аж ахуйн олон улсын стандартыг нягтлан бодох бүртгэлийн хуульд заасны дагуу хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага өсөх хандлагатай байна.

“Дэлгэрэх-Алдар” ХХК хагас суурин маллагаатай үхрийн фермерийн аж ахуйн биологийн хөрөнгийг үнэлж бүртгэж, тайлагнах асуудалд хийсэн судалгааны ажлыг дараах байдлаар дүгнэв.

- Санхүүгийн тайлангийн биологийн хөрөнгийн үзүүлэлтэд толилуулсан дүн байхгүй, биологийн хөрөнгөө бараа материал, үндсэн хөрөнгөнд толилуулдаг. Төл хүлээж авах үеийн олз, гарз болон биологийн хөрөнгийн дахин хэмжилтийн олз, гарзыг бүртгэлд тусгаагүй байсан.
- Биологийн хөрөнгийг ангилахад үхрийн тоо толгойн дүнд эзлэх таваарын биологийн хөрөнгө 3 жилийн дунджаар 25 хувьтай, үржлийн биологийн хөрөнгө 75 хувьтай байна. Биологийн хөрөнгийн ангилал нь цаашдын бүх тооцооллын суурь болж өгнө. Үхрийн насны ангилал бүрээр нэг толгой үхрийн борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнийг тооцоход жил бүр өсөлттэй гарсан. Энэ хугацаанд нэг толгой үхрийн үнэ өссөн байгаа нь харагдаж байна. Үнийн өсөлт бизнесийн орчны олон хүчин зүйлсээс хамааралтай юм. Санхүүгийн байдлын тайланд биологийн хөрөнгийн нийт дүн 2016 онд 14,217.8 мянган төгрөг, 2017 онд 17,930.2 мянган төгрөг, 2019 онд 18,721.6 мянган төгрөгийн дүнгээр толилуулахаар тооцоо хийв. Бодит үнэ цэнийг тооцоход идэвхтэй зах зээл дэх малын зах зээлийн үнийн

мэдээлэл ашигласан. Зах зээлийн үнэ тодорхойгүй бол хязгаарлалттай болно.

- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тооцооноор 2016 онд 640.0 мянган төгрөг, 2017 онд 500.0 мянган төгрөг 2018 онд 1,045.0 мянган төгрөгийн биологийн хөрөнгийн анхдагч хүлээн зөвшөөрөлтийн олз үүссэн. Биологийн хөрөнгийн дахин хэмжилтийн бодит үнэ цэнийн олзыг 2016 онд 3,392.3 мянган төгрөг, 2017 онд 4,332.5 мянган төгрөг, 2018 онд 16,752.4 мянган төгрөгөөр тооцож орлогын дэлгэрэнгүй тайланд толилуулав.
- Дэлгэрэх-Алдар ХХК-ийн биологийн хөрөнгийг гурван тайлангийн үеэр зах зээлийн үнэд суурилсан бодит үнэ цэнийн аргаар үнэлж, санхүүгийн тайланд толилуулсан энэ дүр зураг цаашид шинжилгээ, судалгаанд ашиглах эх үүсвэр болох боломжтой.
- Дэлгэрэх-Алдар ХХК нь биологийн хөрөнгөө санхүүгийн тайланд үнэн зөв толилуулснаар нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл хэрэглэгчдийг үнэн зөв, бодит мэдээллээр хангах боломжтой болно.

Цаашид дэвшүүлэх санал:

1. Үхрийн фермерийн аж ахуй эрхэлж буй компанийн тооны өсөлттэй уялдуулан бүртгэл тайлагналын өнөөгийн байдалд судалгаа хийх, тухайлсан стандарт, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох.
2. Монгол Улстай газар зүйн байршил, цаг агаар, уур амьсгалын хувьд ойролцоо хөрш Хятад, Орос улсын хөдөө аж ахуйн нягтлан бодох бүртгэлийн стандарт, заавар журамтай танилцан харьцуулсан судалгаа хийх.
3. Стандартын дагуу бэлтгэсэн тайлангуудаар судалгаанд ашиглах мэдээллийн санг бий болгох.

Ашигласан материал

- Blinov, O. A., Triyanova, A. S., & Tsimbal, A. A. (2014). Current Issues in Biological Assets Accounting in Russia. *Eastern European Scientific Journal*, 5, 1-4.
- Bödecker, A. & Fladt, G. (2016). *Agriculture In Depth: A Look at Current Financial Reporting Issues*. <https://www.pwc.com/gr/en/media-centre/ifrs-news/assets/ifrs16-a-new-era-of-lease-accounting.pdf>
- Brito, E. D., Ribeiro, M. D. S., Martins, V. A., & Lemes, S. (2014). Fair Value Application to Biological Assets and Agricultural Produce in Livestock Farming. *Asian Journal of Business and Management Sciences*, 3(6), 21-32.
- Maina, P. N. (2010). *Fair Value Reporting Challenges Facing Small and Medium-Sized Entities in the Agricultural Sector in Kenya*. <https://core.ac.uk/download/pdf/43167131.pdf>
- Rejeb, A., Sellami, A., & Zouaoui, A. E. (2017). *The Accounting for Biological Assets: Methods and Issues*. http://www.academia.edu/33588926/ACCOUNTING_Senior_Project_The_Accounting_for_Biological_Assets_Methods
- Silva, R. L. M., Nardi, P. C. C., & Ribeiro M. S. (2015). Earnings Management and Valuation of Biological Assets. *Brazilian Business Review*, 12(4), 1-26.
- Van Biljon, M. (2016). *An Application Guideline for the Fair Value Accounting of Biological Assets*. <http://uir.unisa.ac.za/bitstream/handle>
- Алтанцэцэг, С. (2005). Биологийн хөрөнгө, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг үнэлэх нь. *Хэрэглээний стандарт сэтгүүл*, 08(9).
- Алтанцэцэг, С. (2007). Хөдөө аж ахуйн байгууллагад нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт нэвтрүүлэх нь. *Бүртгэл санхүүгийн тэргүүний ажилтны улсын IV зөвлөгөөний товхимол*.
- Алтанцэцэг, С. (2010). *Мал аж ахуйн бүтээгдэхүүний өртөг тооцох арга зүйн зарим асуудал*. Докторын зэрэг горилсон бүтээл
- Алтанцэцэг, С. (2018). Мал аж ахуйн салбарын нягтлан бодох бүртгэлийн шийдвэрлэх зарим асуудал. *Хэрэглээний стандарт сэтгүүл*, 04(101), 6-9.
- Алтанцэцэг, С. (2019). Мал аж ахуйн салбарын нягтлан бодох бүртгэлийн шийдвэрлэх зарим асуудал. *Хэрэглээний стандарт сэтгүүл*, 01(102), 13-17.
- Алтанцэцэг, С., & Одончимэг, Б. (2016). ХАА-н салбарын нягтлан бодох бүртгэлийн тулгамдсан асуудал. *Тогтвортой хөгжилд нягтлан бодох бүртгэлийн үүрэг, оролцоо ОУЭШХЭмхэтгэл*, 12-21.
- Алтанцэцэг, С., & Одончимэг, Б. (2017). Хөдөө аж ахуйн компаниудын нягтлан бодох бүртгэлийн чадавхийг тодорхойлох нь. *Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт*, 02(32), 17-20.
- Баянмөнх, Г. (2019). Биологийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэл ба татварын асуудал. *Татвар ба Бизнес*, 07(23), 18-29.

Баярхүү, С. & Оюунчимэг, С. (2016). Биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэл тайлагналын зарим асуудал. *Тогтвортой хөгжилд нягтлан бодох бүртгэлийн үүрэг, оролцоо ОУЭШХЭмхэтгэл*, 43-51.

Эрдэнэсоёл, Д. (2019). Биологийн хөрөнгийн үнэлгээний олон улсын туршлага. *Нягтлан бодох бүртгэлийн онол, практик*, 3(1), 69-78.

Дэлгэрэх-Алдар ХХК-ийн үхрийн фермерийн аж ахуйн 2016-2018 оны санхүүгийн тоо мэдээлэл, жилийн эцсийн мал тооллогын дүн.

ММНБИ, (2014). *СТОУС хэрэглээний тайлбар*, Улаанбаатар.

Сангийн яам (2016). Сангийн сайдын 2016 оны 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт.

ХААИС (2017). *Хөдөө аж ахуйн нягтлан бодох бүртгэл*. Улаанбаатар: Маршал принт ХХК.

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны статистик мэдээлэл.

<https://www.iasplus.com/en/standards/ias/ias41>

http://mofa.gov.mn/exp/static/ministry_structure

<https://mof.gov.mn/legacy/minister-order-legacy>

<https://www.1212.mn>

Хавсралт 1. Фермерийн аж ахуй эрхэлдэг компаниудын хувьд ашигладаг нягтлан бодох бүртгэлийн стандарт баримт бичгийн талаар зарим улс орны судалгаа

№	Улс	ХАА-н НББ-ийн хамрах хүрээ	Тайлбар
1	Монгол	НББОУС-41 Үндэсний стандарт болох баримт бичиг	НББОУС-41-д суурилан Сангийн сайдын 2016 оны 411 тушаалаар батлагдсан үндэсний стандарт баталсан. 2015 онд батлагдсан НББ-н хуулийн 4-р зүйлд СТОУС, ЖДААН-ийн СТОУС, УСНББОУС хэрэглэхээр заасан.
2	Малайз	НББОУС-41, Малайзын НББ-ийн стандарт МАС-8	МАС-8 нь НББОУС-16, НББОУС-41-д суурилсан бөгөөд 2014 оноос хэрэглэж байна.
3	Филиппин	НББОУС-41	Гахайн аж ахуй, шувууны аж ахуй, амьтад зэрэг бодит үнэ цэнийн аргыг хэрэглэж болохоор биологийн хөрөнгүүд нь өртгийн сууриар бүртгэж байна.
4	Турк	Туркийн Хөдөө аж ахуйн үйл ажиллагааны стандарт ТАС-41	НББОУС-41-ийн зарчмууд дээр үндэслэсэн ТАС-41-ийн хэрэглээ нь нийцэхгүй боловч бодит үнэ цэнийн нягтлан бодох бүртгэлийн үндэс суурь гэж үздэг. ХАА-н үйл ажиллагааг ихэвчлэн ЖДААН-үүд эрхэлдэг. ЖДААН-ийн биологийн хөрөнгөө үнэлэхдээ идэвхитэй зах зээлийн мэдээлэлд тулгуурладаг, ингэснээр үр дүн нь НББОУС-41-ийн үнэлгээтэй харьцуулагдах боломжтой.
5	Австрали	Өөрөө үйлдвэрлэх, нөхөн төлжүүлэх хөрөнгийг зохицуулах стандартыг AASB-1037 Австралийн ХАА-н стандарт AASB-141	Өөрөө үйлдвэрлэх, нөхөн төлжүүлэх хөрөнгийг зохицуулах стандартыг (AASB-1037) 2001 оны 6-р сарын 30-ны өдрөөс эхлэн боловсруулж хэрэгжүүлэв. Австралийн ХАА-н стандарт AASB-141-ийг 2015 оны 8-р сараас хэрэглэж эхэлсэн. НББОУС-41-ийн үнэлгээтэй харьцуулагдах боломжтой.
6	Литва	Биологийн хөрөнгийн бизнесийн нягтлан бодох бүртгэлийн стандарт BAS-17	2004 оны 10-р сарын 6-ны өдрийн 6-р тогтоолоор Литва улсын Төрийн байгуулалтын стандарт зөвлөл, Нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн баталж 2005 оны 1-р сарын 1-ний өдрөөс мөрдсөн.
7	Бразил	СРС-29 - ХАА СРС-46 - Бодит үнэ цэнийн хэмжилт	СТОУС-тай уялдуулах зорилгоор Бразилд 2005 онд Comitê de Pronunciamentos Contábeis (СРС буюу Нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл)-ийг байгуулсан. Уг зөвлөлөөс НББОУС-41-д нийцүүлэн хөдөө аж ауйн стандарт СРС-29-ийг Бразилын аюулгүй байдлын хорооны 2009 оны 9-р сарын 15-ны өдрийн 595 тогтоолоор батлав.
8	Хятад	ASBE-5 - Biological Assets	Хятад улсын GAAP (Нийтээр хүлээн зөвшөөрсөн НББ-ийн зарчмууд)-ийг CAS (Хятад улсын НББ-ийн стандартууд) гэж нэрлэдэг бөгөөд тэдгээрийг Хятадын Сангийн Яамнаас гаргадаг.
9	Орос	Улсын тусгай стандарт	ОХУ-д СТОУС-ийг нэвтрүүлэх ажлыг 2012 онд эцэслэн боловсруулсан. СЯ-наас томилсон хараат бус байгууллага болох НББ-ийн стандартын үндэсний зөвлөл (NSFO)-ийн техникийн шалгалтанд хамрагддаг.
10	Казакстан	НББОУС-41 , Үндэсний санхүүгийн тайлангийн стандартаар тогтоогдсон загварыг ашигладаг.	Банкнаас бусад аж ахуйн нэгжүүд 2005 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн СТОУС мөрдөх шаардлагатай болсон. Жижиг, дунд бизнес эрхлэгчид Казакстаны Сангийн Яамнаас боловсруулсан үндэсний стандартыг нэмж оруулсан байдаг. Гарын авлага байдлаар гаргасан. Фермерүүдийг хялбаршуулсан НББ-ийн системээр хангадаг. Өртгийн аргыг хэрэглэдэг учир бусад орны фермертэй харьцуулах боломжгүй.

Хавсралт 2. Биологийн хөрөнгийн дахин хэмжилтээс
үүссэн бодит үнэ цэнийн олз, гарз (төгрөг)

№	Нас	Үнийн өөрчлөлтөөс бий болсон БҮЦ-ийн олз, гарз			Биет өөрчлөлтөөс бий болсон БҮЦ-ийн олз, гарз			Борлуулалтаас бий болсон БҮЦ-ийн олз, гарз			Биологийн хөрөнгийн дахин хэмжилтээс үүссэн бодит үнэ цэнийн олз, гарз		
		2016	2017	2018	2016	2017	2018	2016	2017	2018	2016	2017	2018
1	Тугал		160,000	50,000	480,000	800,000	550,000				480,000	960,000	600,000
2	Бяруу		121,544	94,427	3,572,040	5,086,836	3,273,700	4,167,380	3,815,127	4,910,550	(595,340)	1,393,253	(1,542,423)
3	Шүдлэн		22,700	-	4,633,400	6,359,467	4,147,400	3,861,167	7,154,400	2,073,700	772,233	(772,233)	2,073,700
4	Үнээ		486,568	196,850	7,778,492	10,857,891	6,983,032	5,833,869	8,143,418	7,681,335	1,944,623	3,201,041	(501,453)
5	Нийт	-	790,811	341,278	16,463,932	23,104,194	14,954,132	13,862,416	19,112,945	14,665,585	3,392,328	4,332,526	16,752,479